БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/38/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2022 он | Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас: 70642580 Цахим хаяг: Ankhbayrd@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн<br>Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт....2
1.Аудитын санал дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....11
3. Аудитын тайлан....12
3.1 Ерөнхий зүйл....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....13
3.4 Материаллаг байдал....13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....15
3.8 Аудитын гол асуудал....16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
4. Аудитын илрүүлэлт....17
4.1 Залруулсан алдаа....17
4.2 Төлбөрийн акт....17
4.3 Албан шаардлага....17
4.4 Зөвлөмж....18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....20

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 198

танай ________ ны № ________ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020766

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **45,652,504.20** | **61,005,830.04** |
| **33** | **АВЛАГА** | 205,099.16 | 690,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 205,099.16 | - |
| **335** | **Бусад авлага** | - | 690,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 690,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 45,447,405.04 | 58,948,330.04 |
| **351** | **Түүхий эд материал** | 16,579,721.04 | 16,385,721.04 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 16,579,721.04 | 16,385,721.04 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,055,684.00 | 35,494,609.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 614,800.00 | 458,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,150,884.00 | 31,032,809.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,290,000.00 | 4,003,000.00 |
| 35600 | Мал амьтад | 5,812,000.00 | 7,068,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | - | 1,367,500.00 |
| 36100 | Барааны нөөц | - | 1,367,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,750,502,631.05** | **1,838,969,279.95** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,750,502,631.05 | 1,838,969,279.95 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,727,418,631.05 | 1,812,547,779.91 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,873,163,186.42 | 2,976,129,852.42 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,301,342,337.87) | (1,400,152,444.95) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 177,700,000.00 | 98,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (115,635,457.74) | (50,418,790.98) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 100,726,135.02 | 119,876,224.02 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (33,298,660.54) | (53,332,422.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,944,729.04 | 145,028,487.75 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (21,360,129.88) | (23,804,292.48) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 400,466.60 | 400,466.60 |
| 39217 | Ном | 120,700.00 | 120,700.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 23,084,000.00 | 26,421,500.04 |
| 39301 | Програм хангамж | 1,000,000.00 | 5,100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (762,499.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,084,000.00 | 22,084,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,796,155,135.25** | **1,899,975,109.99** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,774,071,135.25** | **1,877,891,109.99** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,774,071,135.25 | 1,877,891,109.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 620,338,407.95 | 620,338,407.95 |
| 51101 | Өмч: - төрийн | 620,338,407.95 | 620,338,407.95 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 537,936,925.61 | 641,756,900.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 537,936,925.61 | 537,936,925.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 103,819,974.74 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 615,795,801.69 | 615,795,801.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,774,071,135.25** | **1,877,891,109.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **783,830,793.27** | **752,310,469.78** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **392,076,678.27** | **243,889,910.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 392,076,678.27 | 243,889,910.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 392,076,678.27 | 243,889,910.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,160,121.00 | 5,712,824.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 387,916,557.27 | 238,177,086.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **391,754,115.00** | **508,420,559.78** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 58,247,777.00 | 63,860,550.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,247,777.00 | 63,860,550.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 333,506,338.00 | 444,560,009.78 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 333,506,338.00 | 444,560,009.78 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **505,592,466.51** | **618,590,764.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **505,592,466.51** | **618,590,764.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 502,261,795.51 | 591,153,889.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 246,501,195.76 | 236,187,344.00 |
| 210101 | Үндсэн цалин | 181,002,096.00 | 176,778,528.00 |
| 210102 | Нэмэгдэл | 42,651,765.76 | 52,691,538.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 22,847,334.00 | 6,717,278.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,408,358.08 | 30,759,913.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,673,821.20 | 21,448,061.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,890,020.00 | 2,327,962.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,971,400.24 | 1,862,370.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 203,416.92 | 465,592.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,669,699.72 | 4,655,925.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,259,895.00 | 42,212,899.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,242,575.00 | 4,499,999.70 |
| 210302 | Түлш, халаалт | 17,017,320.00 | 37,712,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,895,346.00 | 22,632,197.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,155,300.00 | 3,324,585.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,204,830.00 | 9,089,230.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,045,720.00 | 1,995,430.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 45,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 6,769,852.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 756,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 652,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 489,496.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 1,486,400.00 | 366,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,486,400.00 | 366,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,437,400.00 | 10,322,430.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,437,400.00 | 10,322,430.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,228,000.00 | 1,971,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 1,228,000.00 | 1,971,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,430,835.00 | 1,333,445.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,508,985.00 | 150,820.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 380,850.00 | 353,750.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,000.00 | 749,875.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 79,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 176,614,365.67 | 245,368,460.56 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,206,741.00 | 101,922,372.92 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 529,291.00 | 311,570.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 111,878,333.67 | 143,134,517.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,330,671.00 | 27,436,874.74 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,535,000.00 | 19,853,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 18,631,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,535,000.00 | 1,221,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,795,671.00 | 7,583,574.74 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,795,671.00 | 7,583,574.74 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **278,238,326.76** | **133,719,705.28** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 349,376,035.60 | 29,899,730.54 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 290,338,980.98 | 4,131,230.54 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 59,037,054.62 | 25,768,500.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (349,376,035.60) | (29,899,730.54) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(71,137,708.84)** | **103,819,974.74** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 642,422,408.0 | 615,795,801.7 | 609,074,634.5 | | 1,867,292,844.1 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **642,422,408.0** | **615,795,801.7** | **609,074,634.5** | **-** | 1,867,292,844.1 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (71,137,708.8) | | (71,137,708.8) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **642,422,408.0** | **615,795,801.7** | **537,936,925.6** | **-** | 1,796,155,135.3 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **642,422,408.0** | **615,795,801.7** | **537,936,925.6** | **-** | 1,796,155,135.3 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **642,422,408.0** | **615,795,801.7** | **537,936,925.6** | **-** | 1,796,155,135.3 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 103,819,974.7 | | 103,819,974.7 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **642,422,408.0** | **615,795,801.7** | **641,756,900.4** | - | 1,899,975,110.0 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **395,914,236.00** | **514,133,383.78** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,160,121.00** | **5,712,824.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,160,121.00 | 5,712,824.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,160,121.00 | 5,712,824.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,160,121.00 | 5,712,824.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **391,754,115.00** | **508,420,559.78** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 58,247,777.00 | 63,860,550.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,247,777.00 | 63,860,550.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 333,506,338.00 | 444,560,009.78 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 333,506,338.00 | 444,560,009.78 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **391,863,436.00** | **485,067,183.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **391,863,436.00** | **485,067,183.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **389,032,765.00** | **457,252,809.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 246,355,114.00 | 236,187,344.00 |
| 210101 | Үндсэн цалин | 180,932,261.00 | 176,778,528.00 |
| 210102 | Нэмэгдэл | 42,505,684.00 | 52,691,538.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 22,917,169.00 | 6,717,278.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,759,539.00 | 30,554,814.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,551,447.36 | 21,242,962.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,363,574.76 | 2,327,962.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,971,400.24 | 1,862,370.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 203,416.92 | 465,592.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,669,699.72 | 4,655,925.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,341,695.00 | 42,212,899.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,242,575.00 | 4,499,999.70 |
| 210302 | Түлш, халаалт | 13,099,120.00 | 37,712,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,131,320.00 | 22,334,617.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,368,700.00 | 2,653,285.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,716,900.00 | 9,089,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,045,720.00 | 1,995,430.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 160,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 7,436,702.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 599,400.00 | 1,506,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 599,400.00 | 1,506,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,163,300.00 | 14,239,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 223,400.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,939,900.00 | 14,239,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,228,000.00 | 1,971,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,228,000.00 | 1,971,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,162,335.00 | 6,182,625.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,240,485.00 | 5,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 380,850.00 | 353,750.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,000.00 | 749,875.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 79,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 64,292,062.00 | 102,063,359.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 63,632,271.00 | 101,563,789.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 659,791.00 | 499,570.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,830,671.00** | **27,814,374.74** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,035,000.00 | 20,230,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 18,631,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,035,000.00 | 1,599,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 7,583,574.74 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,583,574.74 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,795,671.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,795,671.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,050,800.00** | **29,066,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,050,800.00** | **29,066,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,050,800.00** | **29,066,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,050,800.00 | 29,066,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 4,050,800.00 | 29,066,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(4,050,800.00)** | **(29,066,200.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | (0.00) |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 458,779,600.00 | 443,379,259.04 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 458,779,600.00 | 414,313,059.04 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 438,547,900.00 | 394,082,259.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 248,258,400.00 | 236,187,344.00 |
| 210101 | Үндсэн цалин | 190,885,300.00 | 176,778,528.00 |
| 210102 | Нэмэгдэл | 44,358,100.00 | 52,691,538.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,015,000.00 | 6,717,278.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,514,900.00 | 30,554,814.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,584,500.00 | 21,242,962.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,482,600.00 | 2,327,962.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,986,100.00 | 1,862,370.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 496,600.00 | 465,592.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,965,100.00 | 4,655,925.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,212,900.00 | 42,212,899.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,500,000.00 | 4,499,999.70 |
| 210302 | Түлш, халаалт | 37,712,900.00 | 37,712,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,342,900.00 | 22,334,617.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,653,700.00 | 2,653,285.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,089,200.00 | 9,089,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,000,000.00 | 1,995,430.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 160,000.00 | 160,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,440,000.00 | 7,436,702.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,506,600.00 | 1,506,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,506,600.00 | 1,506,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 33,156,200.00 | 14,239,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,916,200.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 14,240,000.00 | 14,239,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,316,000.00 | 1,971,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,316,000.00 | 1,971,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,390,000.00 | 6,182,625.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 420,000.00 | 353,750.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 800,000.00 | 749,875.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 70,000.00 | 79,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,100,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,850,000.00 | 38,892,809.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,350,000.00 | 38,393,239.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 499,570.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 20,231,700.00 | 20,230,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 20,231,700.00 | 20,230,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,631,700.00 | 18,631,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 1,599,100.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **29,066,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 29,066,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 29,066,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 450,272,833.78 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 444,560,009.78 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 444,560,009.78 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 5,712,824.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 5,712,824.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **58,247,777.00** | **63,170,550.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **56,447,877.00** | **63,170,550.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 56,447,877.00 | 63,170,550.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,000,000.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,240,977.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,240,977.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,206,900.00 | 63,170,550.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,206,900.00 | 63,170,550.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,799,900.00** | **-** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,799,900.00 | - |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,799,900.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 55,247,777.00 | 63,860,550.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 55,247,777.00 | 63,860,550.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,456,800.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,790,977.00 | 63,860,550.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,000,000.00 | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гурванбулаг сумын ЗДТГ нь нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн стратеги төлөвлөлтөнд тулгуурлан төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг тооцох гэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 854,968.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,824.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 9,618.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,146.8 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.00 | 2.00 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | - | - | - |
| **Авлага** | 205.1 | 690.0 | 484.9 |
| **Урьдчилгаа** | - | - | - |
| **Бараа материал** | 45,447.4 | 58,948.3 | 13,500.9 |
| **Үндсэн хөрөнгө** | 1,750,502.6 | 1,838,969.3 | 88,466.7 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | 1,796,155.1 | 1,899,975.1 | 103,820.0 |
| **Өр төлбөр** | - | - | - |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 1,796,155.1 | 1,899,975.1 | 103,820.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,796,155.1 | 1,899,975.1 | 103,820.0 |

Авлага дансны үлдэгдэл 690.0 мянган төгрөг болж мянган 484.9 мянган төгрөгөөр өссөн нь төрөөс олгох усны мөнгө 12 дугаар сарын 31-ний өдөр шилжиж ирсэн, сангийн яам гүйлгээгээ хаасан байсан учир зарцуулж чадаагүй авлагаар илэрхийлсэн нь шалтгаалжээ. Авлага дансны өмнөх онуудад үүссэн эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58,948.3 мянган төгрөг болж 13,500.9 мянган төгрөгөөр өссөн нь ковид цар тахалтай холбоотойгоор материал худалдан авалт, урсгал засварын зардлаас материал худалдан авалт хийж үлдэгдэлтэй гарсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,838,969.3 мянган төгрөг болж 88,466.7 мянган төгрөгөөр өссөн нь ОНХСангийн хөрөнгө оруулалтаар суманд гэрэлтүүлэгийн ажил хийсэн мөн сумын төвд 2ш ухаалаг худаг гаргасан, улсын төсвөөр 2ш худаг гаргасан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 204,015.1 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 29,066.2 мянган төгрөг, нийт 233,081.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй , акталсан 87,780.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,899,975.1 мянган төгрөг болж 103,820.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 33,637.1 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орлого 33637,1 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь санхүүжилт өссөн боловч үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүн буурсан нь нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 112,998.3 мянган төгрөгөөр буюу 22.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглалттай холбоотой тогомол зардал, хангамж бараа материал, бараа үйлчилгээний бусад зардал, төрийн албан хаагч өндөр настны тэтгэвэрт гарах зэрэг зардлууд байна.

Энэ нь халаалт нийтийн халаалтад шилжсэн, ковидтой холбоотой ЗДН хөрөнгийн зардал, урсгал засвар, нэг төрийн албан хаагч өндөр настны тэтгэвэрт гарсан зэргээс зардлууд нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 478,800.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 20,0020.4 мянган төгрөгөөр бууруулан 458,779.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 458,779.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 444,560.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 63,860.5 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 5,71.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 444,560.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,712.8 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 63,860.5, мянган төгрөг нийт 514,133.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 506,546.8 мянган төгрөгийг зарцуулж 7,586.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 25,000.0, стастиктикийн хэлтэсээс 900.0 байгаль хамгаалах сангаас 23,200.0, Өвөрхангай аймгаас гэрээний дагуу 10,000.0, Булган Мээж төрөөс усны үнэ 5,400.0 мянган төгрөгөөр тус тус орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 63,170.5 мянган төгрөгийг зардалд зарцуулж 690.0 мянагн төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу авлага үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Гурван булаг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 117 мэдээлэл оруулахаас 113 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 4 мэдээллийг байршуулаагүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш 4 удаагийн 29,314.7 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх заалттай нийцээгүй;
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 8,668.0, тэмцээн уралдааны зардалд 1,532.7, сурталчилгаа, контентын зардалд 950.0, нийт 11,151.1 төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалттай нийцээгүй;
- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан бөгөөд акт, албан шаардлага, зөвлөмж хүргэгдээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 121,397.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 53,100.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,220.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 54,638.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,439.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үндсэн хөрөнгө /2,920.0/, бараа материал /26,210.0/ нийт 29,130.0 мянган төгрөгийг худалдан авсанаар бүртгэсэн, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 24,000.0 мянган төгрөгийг зарлагдахдаа худалдан зарцуулсанаар бүртгэж журналын бичилт буруу хийсэн алдааг НББ-ийн тухай хуулийн 15.1 дэх заалтын дагуу залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

- Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 1,300.0 мянган төгрөгийг холбогдох журамд нийцэхгүй зардалд зарцуулсан нь Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна. заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- Булган дулаан ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээний орлого 2,610.4 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Анхан шатны баримтын бүрдэлгүй 309.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.11, 13.6, 13.7 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

- Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газар 2021 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 4 худалдан авалтын 29,314.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд халаалтын өглөг 2,610.4 мянган төгрөгийг бүртгэл тайланд илэрхийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14.4.-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-д "бүх өр төлбөр" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчсөн, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 8,668.5,тэмцээн уралдааны зардалд 1,532.7, сурталчилгаа, контентын зардалд 950.0, нийт 11,151.1 төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар

тогтоолын 1.1, 1.4, 1.6, 1.7 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

- Нэмэлт санхүүжилтээс 3,126.2 мянган төгрөгийн шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичиж зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Жилийн эцэст нийт 8,435.5 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй нь ННБ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.2, 73.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Цалингийн зардалтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Бүтэц орон тоонд батлагдаагүй E-mongolia опператаор ажилтанд хавсарсан ажилсны нэмэгдэл цалин /2,722.3/, слесарь, хог тээврийн жолоочийн цалинд / 6.717,3/ нийт 9.439,6 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

***2. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдлийг бүрдүүлж хавсаргаагүй, төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдэл бүрэлдэхүүн хэсгийн дагуу тайлангаа ирүүлээгүй.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу санхүүгийн тайлангийн иж бүрдлийг бүрэн хангаж санхүүгийн тайлан гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Гурванбулаг сумын ЗДТГ | 12 | 121,397.6 | 2 | 53,100.0 | 3 | 4,220.0 | 5 | 54,638.0 | 2 | 9,439.6 |